



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/656 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 1, 2 дугаар хороонд байрлах нуур, тогтоол ус, карьер орчимд иргэд усанд осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хөдөлгөөнт эргүүл”-ийг гаргаж 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын хэлтэс (Б.Өлзийбат), хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т тус тус үүрэг болгосугай.

2.Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг хоёрдугаар, шаардагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах 771,200 (долоон зуун далан нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ/2024 он ажил/захирамж

1123200236

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1106 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага
1	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах	2024.06.14	Онцгой байдлын хэлтэс
2	Үерийн усны буулт бүхий газраар нутаглаж, суурьшсан айл өрхүүдэд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэж, санамж материал тараах	2024.06.15-ны өдрөөс 2024.09.15	Онцгой байдлын хэлтэс 1, 2 дугаар хорооны ажлын алба
3	Дүүргийн 1, 2 дугаар хорооны нуур, тогтоол усны орчимд хамтарсан эргүүл, хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулах	2024.06.15-ны өдрөөс 2024.09.15	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын хэлтэс
4	Үер, уснаас урьдчилан сэргийлэх төрөл бүрийн мэдээлэл, шторк, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэж ажиллах	2024.06.15-ны өдрөөс 2024.09.15	Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын хэлтэс 1, 2 дугаар хорооны ажлын алба
5	Дүүргийн үерийн ус зайлуулах сувгийн ус чөлөөтэй нэвтэрч буй байдалд хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллах	2024.06.15-ны өдрөөс 2024.09.15	Онцгой байдлын хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	Зохион байгуулсан ажлын дүн, мэдээг 2024 оны 9 дүгээр сарын 15-ны дотор дүүргийн Засаг даргад илтгэх хуудсаар танилцуулах	2024.09.15	Онцгой байдлын хэлтэс

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/06 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

д/д	Байгууллагын нэр	Эргүүлээр ажиллах хуваарь		Нийт
		Эхлэх	Дуусах	
1.	Онцгой байдлын хэлтэс, гал түймэр унтраах, аврах 80 дугаар анги	2024.06.17	2023.07.17	8 удаа
2.	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс	2024.07.17	2024.08.16	8 удаа
3.	Онцгой байдлын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	2024.08.16	2024.09.16	8 удаа
Нийт (удаа)				24

Тайлбар:
Дээрх байгууллагууд нь 7 хоногт 2 удаа Эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж мэдээ, илтгэх хуудсыг тухай бүр дүүргийн Онцгой байдлын хэлтэст ирүүлнэ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1106 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	7 хоногт 2 удаа			Бүгд үнэ
			литр	Хэдэн удаа	Нийт (л)	
1.	А-92	2380	10	24	240	571,200
2.	Шуудай	1000	-	-	200	200,000
нийт						771,200